# ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА ХАЛТАРЫН ОЮУНБИЛЭГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Хяналт, дотоод аудитын хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь) | 63.0 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн “Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт”-д хамрагдаж №R1424 дугаартай сертификаттай төгссөн. | 100% | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. Цаг уур, орчны шинжилгээний газар болон харьяа байгууллагуудын албан хаагчдад "Авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан, нөхцөл" сэдэвт сургалт хамрагсан. | 80% | 12 |
| 3. | Арга хэмжээ 3. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Сэтгэцийн эрүүл мэнд ба Ёс зүй, Стресс менежмент” сэдэвт сургалтад хамрагдсан. | 80% | 12 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 13 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 14 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 14 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 14 |
| 4. | Манлайлах | 14 |
| 5. | Багаар ажиллах | 14 |
| 6. | Харилцаа | 14 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | *70 хүртэлх оноо* |

| | | |
|---|---|---|
| | *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 63 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>13 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>14 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6  дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | 90 оноо |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | |

**Үнэлгээ өгсөн:**
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА

2025 оны 12 дугаар сарын ...

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ОЮУНБИЛЭГ

2025 оны 12 дугаар сарын ...

# ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Арга хэм-жээ | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин сүүлийн хагас жил | Хүрсэн түвшин | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | Зорилт 1. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, ЦУОШГ-ын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана. | | | | | | |
| Зорилт 1: | | Бодлогын баримт бичиг, ЦУОШГ, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | 0 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг цахим системд байршуулсан тоо | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагын цахим системд байршуулсан. | Хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж, тайланг цахим системд байршуулсан байна. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө", ЦУОГШ-ын 2025 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж, www.namem.gov.mn, www.shilen.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан. | 90% |
| 1 | 1.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; | - | Тайлангийн тоо-1 | - | 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2025 оны жилийн эцсийн тайланг холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэн байна. | ЦУОШГ-ын 2025 оны жилийн эцсийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/917 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тайланг namem.gov.mn цахим хаягт ил тод байдлын хяналт, дотоод аудит цэс | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Тайланг цахим системд байршуулсан байна. | хэсэгт байршуулж, ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллав. | |
| 2 | 1.2 | Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т ЦУОШГ-ын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх | - | Тайлангийн тоо-1 | - | 1. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулгыг удирдлагад танилцуулж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>2. Тайланг цахим системд байршуулсан байна. | Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т ЦУОШГ-ын хариуцан хэрэгжүүлэх 4 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/917 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Арга хэмжээ тус бүрийн холбогдох баримтыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн ба 4 арга хэмжээний дундаж биелэлт 65 хувьтай дүгнэгдсэн байна.<br>Тайланг namem.gov.mn цахим хаягт ил тод байдлын хяналт, дотоод аудит цэс хэсэгт байршуулж, ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллав. | 90% |
| 3 | 1.3 | “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд ЦУОШГ-ын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны биелэлтэд хяналт- | - | Тайлангийн тоо-1 | - | - | 1. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусгадсан ЦУОШГ-ын хариуцан хэрэгжүүлэх 5 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ахлах шинжээч | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинжилгээ үнэлгээ хийх | | | | | С.Баясгаланд 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн цахимаар хүргүүлсэн ба 5 арга хэмжээний дундаж биелэлт 68 хувьтай дүгнэгдсэн байна.<br>2 Тайланг namem.gov.mn цахим хаягт ил тод байдлын хяналт, дотоод аудит цэс хэсэгт байршуулж, ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллав. | |
| 4 | 1.4 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд ЦУОШГ-ын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх | - | Тайлангийн тоо-1 | - | 1. 2025 оны жилийн эцсийн үнэлгээг удирдлагад танилцуулж, үнэлгээний тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>2. Тайланг цахим системд байршуулсан байна. | Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан ЦУОШГ-ын хариуцан хэрэгжүүлэх 2 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/917 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Арга хэмжээ тус бүрийн холбогдох баримтыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн ба 2 арга хэмжээний дундаж биелэлт 50 хувьтай дүгнэгдсэн байна.<br>Тайланг namem.gov.mn цахим хаягт ил тод байдлын хяналт, дотоод аудит цэс хэсэгт байршуулж, ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллав. | 90% |
| 6 | 1.6 | Байгууллагын болон бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний | - | Тайлангийн тоо-1 | - | 1. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын | 1. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу ЦУОШГ-ын 2025 оны жилийн эцсийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах; | | | | зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.<br>2.Зөвлөмж гарган холбогдох газар хэлтэст хүргүүлсэн байна. | багц тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ЦУОШГ-ын 2025 оны жилийн эцсийн тайлан 93 хувьтай дүгнэгдсэн ба Тайланг namem.gov.mn цахим хаягт ил тод байдлын үйл ажиллагааны цэсэнд байршуулав. | |
| 7 | 1.7 | Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах; | - | Тайлангийн тоо-1 | - | Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тайлангийн дүгнэлт зөвлөмж гарсан байна. | ЦУОШГ-ын даргын 2025.11.11-ны А/243 тоот тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Салбарын “Нийтийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг шалгаж мэдээ мэдээллийг оруулах танилцуулга, зөвлөмж бичсэн. www.shilen.gov.mn-д мэдээ мэдээллийг цаг тухайд нь оруулах, албан хаагчийг томилон ажиллуулах, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайланд дурдсан зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх 2025.11.07-ны 01/794 албан тоотоор 25 байгууллагад хүргүүлсэн. | 100% |
| 8 | 1.8 | Олон улсын зээл, тусламжаар салбарт хэрэгжиж төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | Тайлангийн тоо-1 | - | | Олон улсын зээл, тусламжаар салбарт хэрэгжиж төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй. | Үнэлэх боломж-гүй |
| 9 | 1.9 | ЦУОШГ-ын “А” ангилалд хамаарах тушаалын | - | Тайлангийн тоо-1 | - | А тушаалын хэрэгжилтийг гаргасан байна. | ЦУОШГ-ын даргын А ангиллын нийт 298 тушаал албажиж гарсан ба дотоод хяналт шалгалттай холбоотой А | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | | | | тушаалыг авч тухай бүр хяналт тавьж ажилласан. | |
| 10 | 1.10 | Харьяа 25 байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | Тайлангийн тоо-2 | - | Үнэлгээний дүнг албажуулсан байна. | Харьяа 25 байгууллагын хагас, бүтэн жилийн тайлан, ЦУОШГ-ын алба хаагчдын 2025 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлын хэсгийг ахалж тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг танилцуулж, албан хаагчдын улирлын мөнгөн урамшуулал олгох тушаал албажиж гарсан байна. | 100% |
| 11 | 1.11 | Салбарын албан тушаалтны хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн албан бичиг, өргөдөл гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд дотоод хяналт шалгалт хийж, тайлагнах; | - | Өргөдөл гомдол шалгах хугацаа | 30 хоног | Өргөдөл гомдлыг 28 хоногийн хугацаанд шийдвэрлэж, хариуг гомдол гаргагчид хүргүүлсэн байна. | ЦУОШГ-ын даргын шуурхай үүрэг даалгавар болон бусад харьях байгууллагын албан хаагчаас төрийн албан хаагчид гаргасан нийт 12 өргөдөл гомдлын дагуу дотоод хяналт шалгалт хийж тус бүр танилцуулгыг газрын даргаар албажуулж, зөрчил гаргасан нийт 6 албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулах санал гарч нийт 6 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан байна. | |
| Зорилт 2. Агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | | | | | | | |
| Зорилт 2. | | Салбарын харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх. | 10.0 | Тайлан, танилцуулгын тоо | Тайлан, танилцуулгын тоо | Дотоод аудит хийж, удирдлагад танилцуулан, дүгнэлт, зөвлөмж гарсан байна. | Нийт 4 төлөвлөгөөт бус аудитын тайлан, шилэн дансны 4 улирлын тайланг www.namem.gov.mn, www.shilen.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 2.1 | Агентлаг, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх | 10.0 | Дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлсэн тоо | Дотоод аудитын төлөвлөгөө батлуулсан байна. | 4 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, тайланг удирдлагад танилцуулж, зөвлөмж хүргүүлсэн байна.<br>- Тайлан холбогдох газарт зөвлөмж хүргүүлсэн байна. | 1.2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм" холбогдох бусад хууль тогтоомж, журмыг тус тус удирдлага болгон Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ус, цаг уур, орчны шинжилгээний төв (УЦУОШТ)-д төлөвлөгөөт бус дотоод аудит хийх удирдамжийн дагуу 2024 оноос 2025 оны эхний хагас жилийн байдлаарх захиргаа, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод аудит хийж төвийн даргын А, Б тушаал, боловсон хүчний баримт бичиг, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, зарцуулалт үр дүн, орлого зарлага болон ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, бусад холбогдох зааврын мөрдөлт зэрэгт хяналт шалгалт илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах 16-21 зөвлөмжийг байгууллага тус бүрд тайланг хүргүүлсэн.<br>2. ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалт, эд хөрөнгийн тооллогод тус тус дотоод аудит хийсэн. ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолтоор 6 асуудал илэрч, алдаа дутагдлыг арилгаж, цаашид гаргахгүй байх 9 зөвлөмж гаргаж, тайланг албажуулсан.<br>Нийт 4 төлөвлөгөөт бус аудитын тайланг www.namem.gov.mn, www.shilen.gov.mn | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан. | |
| 18 | 2.2 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 25 байгууллагын шилэн дансны цахим мэдээлэлд дотоод хяналт хийж тайлан мэдээ гаргах; | - | Тайлангийн тоо-4 | Тайлангийн тоо 4 | Шилэн дансны мэдээлэлд улирал бүр дотоод хяналт хийж, тайланг БОУАӨЯ-нд хүргүүлсэн байна.<br><br>Дүгнэлтийн дагу холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлсэн байна. | Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж мэдээллийн санд мэдээлэл оруулсан байдлыг тухай бүр шалган, 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1, 2, 3-р улирлын шилэн дансны хэрэгжилтийн танилцуулгыг нийт 4 удаа гаргасан. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт 2025 оны 3-р улирлын байдлаар нийт 99.4% гарч, өмнөх оны мөн үеэс 0.2%-иар чанар сайжирсан үзүүлэлттэй дүгнэгдсэн.<br>“Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээллийг ангилал тус бүрээр байгууллагын цахим хуудас болон www.shilendans.gov.mn сайтад байршуулан иргэд, олон нийтэд мэдээллээ ил тод, хуулийн хугацаанд байршуулсан эсэхийг хяналт тавин ажилласан. 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны 1, 2, 3-р улирлуудын шилэн дансны танилцуулга, хэрэгжилтийг гаргаж БОУАӨЯ-нд 01/33, 01/210, 01/451, 01/755 дугаар албан бичгээр нийт 4 удаа хүргүүлсэн. | |
| 19 | 2.3 | Шаардлагатай тохиолдолд харьяа байгууллагад төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх; | - | Дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлсэн тоо | - | -Шаардлагатай тохиолдолд байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, тайланг удирдлагад танилцуулсан байна. | 1. “Уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уурын хэмжих хэрэгсэл, сэлбэг материал” нийлүүлэх /ЦУОШГ/20250601020/ дугаартай тендерийн гүйцэтгэгчээр шалгарсан “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ний нийлүүлсэн 3 төрлийн нийт 18 хэмжих хэрэгслүүд шаардлага хангахгүй, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Зөвлөмж хүргүүлсэн байна. | буцаагдсан асуудалд хяналт шалгалт хийсэн танилцуулга, дүгнэлтийн дагуу газрын 2 албан хаагч, харьяа байгууллагын 2 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан.<br>2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүлийн 48.2.3.-д заасны дагуу үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавихад “Төв, орон нутгийн интернэтийн үйлчилгээ” ЦУОШГ/20250103001 дугаар бүхий тендерийн үнэлгээний хорооны нийт гишүүдийн 100 хувийн саналаар шалгаруулсан “ЭС АЙ СИ ТИ” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжид дотоод хяналт хийж, хууль тогтоомжид нийцэхгүй байгааг илрүүлж зөвлөмжийг буцаасан.<br>3. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 2.2.1.12-д заасны дагуу Ус цаг уурын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж иргэд, аж ахуйн нэгж, албан хаагчдаас хандивын орлого, зарлагын дэлгэрэнгүй тайланг ЦУОШГ-ын шилэн данс https://shilendans.gov.mn/, байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдал | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | https://namem.gov.mn/ байршуулах зөвлөмж өгсөн. | |
| 20 | 2.4 | Харьяа байгууллагуудад дотоод хяналт шалгалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Авлигын эсрэг цахим сургалт, мэдээлэл хийх | - | Сургалтын тоо-3 | - | Мэдээллийн цагаар цахим сургалт зохион байгуулсан байна. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдөр ЦУОШГ-ын харьяа 25 байгууллагын удирдлага албан хаагчдад “Шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, тайланг хянах, үнэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл засварлах” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулсан. surgalt-shilen.gov.mn Friday, December 19 · 3:00 – 6:00pm Time zone: Asia/Ulaanbaatar Google Meet joining info Video call link: https://meet.google.com/mdm-vtgi-ofe Авлигыг мэдээлэх 110 дугаарыг харьяа бүх байгууллагын мэдээллийн самбарт түгээж сурталчилсан бөгөөд салбарын хэмжээнд ажиллаж байгаа Нийтийн албан тушаалтнуудад 11 дүгээр сарын 20-ны өдөр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” цахим сургалт, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран “Мэдэгдэл, тайлбарыг ямар үед гаргах, хамаарал бүхий этгээддээ захиргааны шийдвэр гаргасан тохиолдолд хуулийн ямар арга хэмжээ авагдах вэ” сэдэвт цахим сургалтуудыг зохион байгуулж нийт 104 албан хаагч хамрагдсан. | 100% |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Удирлагын академийн дунд хугацааны сургалтад хамрагдах | Сертификатын тоо-1 | - | Сертификат авсан байна. | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн “Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт”-д 2025 онд хамрагдаж 3 голч оноотой төгсөж, №R2434 дугаартай сертификат авсан. | 01-06 | 100% |
| 2. | Арга хэмжээ 2. Байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах | Сургалтын тоо-1 | Сургалтын тоо-1 | Сургалтад хамрагдсан байна. | “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” цахим сургалт, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран “Мэдэгдэл, тайлбарыг ямар үед гаргах, хамаарал бүхий этгээддээ захиргааны шийдвэр гаргасан тохиолдолд хуулийн ямар арга хэмжээ авагдах вэ” сэдэвт цахим сургалт,<br>“Шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, тайланг хянах, үнэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл засварлах” сэдэвт сургалт,<br>“Сэтгэцийн эрүүл мэнд ба Ёс зүй, стресс менежмэнт” зэрэг сургалтад хамрагдсан. | 06-12 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Х.ОЮУНБИЛЭГ

2025 оны 12 дугаар сарын 20